



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2021/117/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.6.3 Нэмэлт санхүүжилт	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8. Аудитын гол асуудал.....	13
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арванхоёр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253
E-mail: ovorkhangai@audit.gov.mn

Аудит № 73

Танай _____-ны № _____-г

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДСЭН ТӨВИЙН ДАРГА
Б.АНХТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, ш: лгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж 3 жилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\Auditin gazartbaiguullagijn dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiiin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,944,511.50</u>	<u>78,285,668.19</u>
33	АВЛАГА	00.00	341,126.69
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	319,336.54
335	Бусад авлага	00.00	21,790.15
3351	Байгууллагаас авах авлага	00.00	21,790.15
35	БАРАА МАТЕРИАЛ	77,944,541.50	77,944,541.50
354	Хангамжийн материал	77,944,541.50	77,944,541.50
35410	Бичиг хэргийн материал	65,000.00	65,000.00
35420	Аж ахуйн материал	240,000.00	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	77,639,541.50	77,639,541.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>167,308,022.45</u>	<u>53,248,439.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	167,308,022.45	53,248,439.11
392	Биет хөрөнгө	159,266,315.85	47,484,272.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,666,666.56	26,666,666.56
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,555,555.42	-14,777,777.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	685,027,274.20	695,027,274.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-583,684,872.86	-693,732,941.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,466,010.96	95,466,010.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,653,167.59	-61,164,959.91
393	Биет бус хөрөнгө	8,041,666.60	5,764,166.56
39301	Програм хангамж	16,238,917.57	16,238,917.57
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,197,250.97	-10,474,751.01
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>245,252,563.95</u>	<u>131,534,107.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>663,663.00</u>	<u>1,188,244.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	663,663.00	1,188,244.00
413	Өглөг	663,663.00	1,188,244.00
4136	Бусад өглөг	663,663.00	1,188,244.00
41361	Байгууллагад төлөх өглөг	663,663.00	1,188,244.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>244,588,900.95</u>	<u>130,345,863.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	244,588,900.95	130,345,863.30
512	Хуримтлагдсан үр дүн	244,588,900.95	130,345,863.30
51210	Өмнөх үеийн үр дүн	244,588,900.95	244,588,900.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-114,243,037.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>245,252,563.95</u>	<u>131,534,107.30</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	158,854,955.68	104,022,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,683,986.68	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,683,986.68	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,683,986.68	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,683,986.68	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	120,170,969.00	104,022,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,066,969.00	11,800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,066,969.00	11,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,104,000.00	92,222,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,104,000.00	92,222,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	222,562,052.37	218,265,637.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,562,052.37	218,265,637.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222,415,223.22	218,034,696.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,105,719.24	65,582,361.69
210101	Үндсэн цалин	61,212,506.24	62,986,693.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,893,213.00	2,595,668.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,652,351.61	8,166,160.76
210201	Тэтгэврийн даатгал	6,042,857.77	5,565,620.51
210202	Тэтгэмжийн даатгал	652,333.46	655,009.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	532,598.77	524,007.89
210204	Ажилгүйдлийн даатгал	119,774.69	129,229.34
210205	Эрүүл мэндийн даатгал	1,304,746.92	1,292,293.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	4,374,581.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	4,374,581.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,918,546.50	3,438,809.85
210401	Бичиг хэрэг	1,349,600.00	1,020,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,926,946.50	1,483,809.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	277,000.00	305,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,057,250.00	3,347,700.00
210604	Урсгал засвар	10,057,250.00	3,347,700.00
2107	Томилолт, зочны зардал	179,200.00	386,500.00
210702	Дотоод албан томилолт	179,200.00	386,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,949,904.00	8,679,000.00

**Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,560,004.00	8,613,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	01.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,900.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,552,251.87	124,059,583.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,655,378.00	01.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,896,873.87	124,059,583.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,829.15	230,941.01
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	146,829.15	230,941.01
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,829.15	230,941.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-63,707,096.69	-114,243,037.65
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-63,707,096.69	-114,243,037.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	120,170,909.00	104,022,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	120,170,969.00	104,022,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,066,969.00	11,800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,066,969.00	11,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,104,000.00	92,222,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,104,000.00	92,222,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	108,740,969.00	94,022,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,740,909.00	94,022,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,594,139.85	93,791,658.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,105,719.24	65,582,361.69
210101	Үндсэн цалин	61,212,506.24	62,986,693.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,893,213.00	2,595,668.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,652,351.61	8,485,497.30
210201	Тэтгэврийн даатгал	6,042,857.77	5,884,957.05
210202	Тэтгэмжийн даатгал	652,373.46	655,009.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	521,898.77	524,007.89
210204	Ажилгүйдлийн даатгал	130,474.69	129,229.34
210205	Эрүүл мэндийн даатгал	1,304,746.92	1,292,293.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	3,850,000.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	3,850,000.00

**Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	Хангамж, бараа материалын зардал	4,282,000.00	3,460,600.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,327,000.00	1,505,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305,000.00	305,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,935,000.00	3,347,700.00
210604	Урсгал засвар	9,935,000.00	3,347,700.00
2107	Томилолт, зочны зардал	179,200.00	386,500.00
210702	Дотоод албан томилолт	179,200.00	386,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,039,869.00	8,679,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,649,900.00	8,613,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	01.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,900.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	01.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	01.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,829.15	230,941.01
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	146,829.15	230,941.01
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	146,829.15	230,941.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,430,000.00	10,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,430,000.00	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,430,000.00	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,430,000.00	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,430,000.00	10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,430,000.00	-10,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	308,295,997.64	00.00	308,295,997.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	308,295,997.64	00.00	308,295,997.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-63,707,096.69	00.00	-63,707,096.69
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	244,588,900.95	00.00	244,588,900.95
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	244,588,900.95	00.00	244,588,900.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	244,588,900.95	00.00	244,588,900.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-114,243,037.65	00.00	-114,243,037.65
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	130,345,863.30	00.00	130,345,863.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,222,600.00	91,991,658.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,222,600.00	91,991,658.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,222,600.00	91,991,658.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,613,600.00	65,582,361.69
210101	Үндсэн цалин	62,841,600.00	62,986,693.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,772,000.00	2,595,668.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,671,600.00	8,485,497.30
210201	Тэтгэврийн даатгал	6,102,200.00	5,884,957.05
210202	Тэтгэмжийн даатгал	642,300.00	655,009.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	513,900.00	524,007.89
210204	Ажилгүйдлийн даатгал	128,500.00	129,229.34
210205	Эрүүл мэндийн даатгал	1,284,700.00	1,292,293.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,850,000.00	3,850,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,850,000.00	3,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,460,600.00	3,460,600.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,548,100.00	1,505,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,500.00	305,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,547,700.00	1,547,700.00
210604	Урсгал засвар	1,547,700.00	1,547,700.00
2107	Томилолт, зочны зардал	400,100.00	386,500.00
210702	Дотоод албан томилолт	400,100.00	386,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,679,000.00	8,679,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,613,000.00	8,613,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	66,000.00	66,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,800,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,800,000.00
210604	Урсгал засвар		1,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		10,000,000.00
222001	Тоног төхөөрөмж		10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	11800000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		11,800,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг 2022.01.10-аас 2022.01.12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.01.10-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь төрийн үйлчилгээг нэг дороос тэгш хүртээмжтэй хүргэж, гомдол мэдээллийг шуурхай шийдвэрлэн, хяналтын камераар иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хотын соёлыг төлөвшүүлэх гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Татварын Ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийг зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 218,265.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,182.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,746.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113,718.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд нийгмийн даатгалын хэлтэс рүү нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэнтэй холбоотой 341.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 54,832.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 4,296.5 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 92,222.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 92,222.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 92,222.6 мянган төгрөгийн төсөв баталж төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 92,222.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 91,991.7 мянган төгрөгийг зарцуулж 230.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвөөс 11,800.0 мянган төгрөгийн орлого орж компьютер, принтер худалдан авахад 10,000.0 мянган төгрөг, машины сэлбэг хэрэгсэл худалдан авахад 1,512.0 мянган төгрөг, барилгын материал худалдан авахад 144.0 мянган төгрөг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8. Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон цахим системд байршуулсан мэдээллийг шалгахад Шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 134 мэдээлэл хугацаандаа байршуулж 16 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитын тулгалтаар 12380.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлогыг шилэн дансны сайтад байршуулаагүй зөрчил илэрсэн түүний хэрэгжилтийг тус байгууллагын даргын 2021 оны 5 дугаар сарын 25-ны 37 тоот албан бичгээр ирүүлж зөрчлөө арилгасан байна.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн бөгөөд жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэхдээ явсан км, түлш шатахууны хэтрэлт, хэмнэлтийг гаргаагүй, нягтлан бодогч тооцоо бодож гарын үсэг зурж баталгаажуулаагүйд албан шаардлага хүргүүлж үр өгөөж тооцов.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар горим сорилыг хэрэгжүүлэхэд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдөж 1 залруулга хийгдсэн болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тооллогоор баталгаажуулсан бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайлангийн тодруулгад тусгасан үлдэгдэлтэй 24,466.8 мянган төгрөгөөр зөрсөнд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитын явцад акт өгөгдөөгүй.

4.3 Албан шаардлага

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын дагуу хөтлөөгүй 300.0 мянган төгрөгийг шилжүүлсэнд 1 албан шаардлага өгөгдсөн.

4.4 Зөвлөмж

Аудитын явцад Шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 134 мэдээлэл хугацаандаа байршуулж 16 мэдээлэл хугацаа хоцроосонд 1 зөвлөмж өгөгдсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	3	24.8	1	24.5			1	0.3	1	
Дүн		3	24.8	1	24.5			1	0.3	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төрийн үйлчилгээний нэгдсэн төв											
Дүн											
Нийт дүн		3	24.8	1	24.5			1	0.3	1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Э.ЭНХБАЯР

2022 ОНЫ 02 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР